

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	2
2. Аудитын тайлан	4
2.1. Оршил	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	6
2.9. Зорилтот түвшин, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
2.12. Шилэн дансны мэдээлэл.....	8
2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	8
2.14. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	8
3. Менежментийн захидал.....	9
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	11
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	11
4.2 Аудит хийсэн Орлогын дэлгэрэнгүй тайлан	13
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	14
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	16
4.5 2019 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшингийн гүйцэтгэл	17
5. Алдаа, зөрчлийн нэгтгэл.....	18

Товчилсон үгийн жагсаалт

СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2020.03.13 № 06/817
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв ТӨҮГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв ТӨҮГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн стандартад болон холбогдох хууль тогтоомжийн дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв ТӨҮГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага


Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв ТӨҮГ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ



2. Аудитын тайлан

2.1. Оршил

Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв ТӨҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, тодруулгад хийсэн аудитын дүн, дүгнэлтийг захирал Ц.Цэрэн танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчид авлагыг тооцоо нийлж баталгаажуулж байх, хөрөнгийг зөв ангилан бүртгэх, хөрөнгө тооллого хийсний дараа тооцоо хийж баталгаажуулж байх зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв ТӨҮГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайланд аудит хийлээ.

Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв ТӨҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт гаргах нь энэхүү аудитын зорилт байв.

Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв ТӨҮГ-ын удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг НББОУС, СТОУС болон холбогдох бусад стандартад нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан дээрх хууль, стандарт болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 12 дугаар сарын 24-нөөс 2020 оны 03 дугаар сарын 10-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 03 дугаар сарын 15-ны өдөр эцэслэн баталгаажуулж, байгууллагын удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, “Цэгцтөв богд аудит” ХХК-ийн аудитор Г.Цэцэгмаа, аудиторын туслах Б.Баярмаа нар хариуцаж хэрэгжүүлэв.

Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв ТӨҮГ-ын 2019 оны санхүүгийн тайланг “Цэгцтөв Богд Аудит” ХХК-д 2020 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 1/042 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, НББОУС, СТОУС, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв ТӨҮГ “Төрөөс эрчим хүчний талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэхтэй холбоотой сэргээгдэх эрчим хүчний нөөцийн нарийвчилсан хэмжилт судалгаа хийх, эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын захиалгаар төсөвт судалгаа шинжилгээний ажлыг гүйцэтгэх, сэргээгдэх эрчим хүчний чиглэлээр хэрэгжүүлэх төслийн техник, эдийн засгийн үндэслэл, судалгаа, зураг төсөл боловсруулах, сэргээгдэх эрчим хүчний барилга байгууламжид техникийн хяналт тавих, гадаад, дотоодод үйлдвэрлэсэн сэргээгдэх эрчим хүчний тоног төхөөрөмжид туршилт хийх, магадлал гаргах, шинээр баригдах эрчим хүчний эх үүсгүүрийн хүлэмжийн хийн ялгарлын бууралтад магадлал нотоолгоо хийх, сэргээгдэх эрчим хүчний шинэ эх үүсгүүр барих, тоног төхөөрөмж угсрах, сургалт зохион байгуулж сэргээгдэх эрчим хүчийг хөгжүүлэн ажиллахад оршиж байна.” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажилладаг байна.

Улсын бүртгэлийн гэрчилгээнд Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв ТӨҮГ-ын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Нарны зайн үйлдвэрлэл, сэргээгдэх эрчим хүчний тоног төхөөрөмжийн худалдаа
- Сэргээгдэх эрчим хүчний чиглэлээр туршилт, судалгаа хийх, зураг төсөл боловсруулах, зөвлөгөө өгөх

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын тухай хуулиар ажил олгогч болон даатгуулагчаас төлөх шимтгэлийн хувийг 0.5 хувиар нэмэгдүүлсэн;
- Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд заасан хөнгөлөгдөх татварын хэмжээг татвар ногдуулах орлогын хувь хэмжээнээс хамаарч өөрчлөлт орсон байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв ТӨҮГ-ын Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв ТӨҮГ нь санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Венеца” програм хангамж ашигладаг байна.

Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв ТӨҮГ-ын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “бага” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв ТӨҮГ-ын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 26 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 10 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлогыг сонгов.

Төрийн өмчит үйлдвэрийн газар орлого олох зорилготой тул материаллаг байдлын суурийг орлоготой уялдуулсан болно.

Материаллаг байдлын түвшинг сонгосон суурь үзүүлэлтээс 2 хувиар тооцсон нь гүйцэтгэлийн үе шатны эрсдэлийг бага гэж үнэлсэнтэй холбоотой юм.

Төлөвлөлтийн үе шатанд 2018 оны жилийн эцсийн орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлого 1,604.9 сая төгрөгийн 2 хувь болох 32.1 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг дахин тооцоолоогүй болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв ТӨҮГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 61.1 сая төгрөгөөр буюу 2.8 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	141.2	28.6	(112.6)
Авлага	84.0	268.8	184.8
Урьдчилгаа	52.5	5.5	(47.0)
Бараа материал	190.1	158.4	(31.7)
Үндсэн хөрөнгө	1,773.3	1,718.7	(54.6)
Нийт хөрөнгө	2,241.1	2,180.0	(61.1)
Өр төлбөр	130.2	292.1	161.9
Эздийн өмч	2110.9	1,887.9	(223.0)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	2,241.1	2,180.0	(61.1)

Авлага дансны үлдэгдэл өссөн нь авлага дансны үлдэгдэлд тайлант онд гэрээт ажлын төлбөр 197.3 сая төгрөг барагдаагүйгээс шалтгаалсан байна. Харилцагч байгууллагаас авах 71.2 сая төгрөгийн авлагаас насжилт өндөртэй тооцоо нийлж баталгаажуулаагүй 13.6 сая төгрөгийн авлага байна.

Үндсэн хөрөнгө хөрөнгө оруулалтаар бэлтгэсэн 56.4 сая төгрөг, өөрийн хөрөнгөөр худалдаж авсан 0.9 сая төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл өссөн нь гэрээт ажлын төлбөрөө бүрэн барагдаагүйгээс бараа ажил үйлчилгээний төлбөрийг хийх эх үүсвэр дутагдсан нь шалтгаалжээ.

Өр төлбөр дансны үлдэгдэлд татварын өр 111.8 сая, ТӨБЗГ-т төлөх түрээсийн орлогын хуримтлагдсан өр 29.2 сая төгрөг, ногдол ашгийн өглөг 59.6 сая төгрөг, харилцагч байгууллагуудад өгөх өглөг 77.6 сая төгрөгийн өр төлбөр байна.

2.9. Зорилтот түвшин, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д заасны дагуу зорилтын саналыг, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага нь энэ хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3-т “Төрийн өмчит хуулийн этгээд дагаж мөрдөх төлөвлөлт, ашиг орлогын хуваарилалтыг холбогдох байгууллагатай тохиролцон тогтоох” гэж заасныг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн 472 дугаар тогтоолоор Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төвийн 2019 оны зорилтот түвшнийг 997.0 сая төгрөгийн орлоготой, 993.5 сая төгрөгийн зардалтай, 3.5 сая төгрөгийн ашигтай байхаар баталсан байна.

Тайлант онд 852.4 сая төгрөгийн орлого бүрдүүлж 1,005.6 сая төгрөгийн зардал гаргаж 153.2 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Батлагдсан төлөвлөгөөгөөр орлого 144.6 сая төгрөгөөр тасарсан нь 268.0 сая төгрөгийн гүйцэтгэсэн ажлыг хүлээлгэн өгөх актын бүрдэл дутуу шалтгаанаас орлогоор хүлээн зөвшөөрөөгүйгээс, зардлын гүйцэтгэл 12.2 сая төгрөгөөр хэтэрсэн нь олон улсын зөвлөхийн ажлын хөлс, байгууллагын эзэмшлийн дулааны шугам хагарсны засварын зардал зэрэг төлөвлөгдөөгүй зардлаас тус тус шалтгаалсан байна.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 10 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 3 эрсдэл тодорхойлж нийт 13 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 15.0 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 1.4 сая төгрөгийн зөрчилд акт тогтоож, 13.6 сая төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө. Үүнд:

Хүлээн авалтын болон хувийн хэрэглээний зардалд төлсөн Нэмэгдсэн өртгийн албан татварыг төсөвт төлөх НӨАТ-аас хасч тооцсон нь Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.6-т “Дараах бараа ажил үйлчилгээг импортоор оруулах, худалдаж авахад төлсөн албан татварыг албан татвар суутган төлөгчийн төлөх уг албан татварын нийт дүнгээс хасахгүй: 14.6.2 хувийн болон ажиллагсдын хэрэгцээнд зориулан худалдаж авсан бараа ажил үйлчилгээ” гэж заасантай нийцээгүй, үнэн зөв батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоосон

Аудитаар илэрсэн 13.6 сая төгрөгийн алдаа, зөрчилд 3 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв ТӨҮГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитын явцад анхаарал татахуйц эрсдэлтэй асуудал гараагүй болно.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуульд жил, улирал, сар, тухай бүр оруулах 60 мэдээллийг хуулийн хугацаанд байршуулсан байна.

2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 3 зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

2.14. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв ТӨҮГ-ын 2019 оны санхүүгийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Залруулагдаагүй 15.0 сая төгрөгийн алдаа, зөрчлийн дүн бидний тогтоосон 16.6 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул зөрчилгүй санал дүгнэлт өгч байна.

Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв ТӨҮГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, стандартад нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв ТӨҮГ-ын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Балансын данстай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

Компьютер болон дагалдах хэрэгслийг машин тоног төхөөрөмжийн дансанд бүртгэсэн нь Сангийн Сайдын 2017 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 361 дүгээр тушаалаар батлагдсан Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайланг бэлтгэх зааварын 2 дугаар бүлгийн Санхүүгийн байдлын тайланд эргэлтийн бус хөрөнгийг дараах байдлаар ангилна хэсгийн (е)-д “Компьютер, бусад хэрэгсэл: Компьютер, хэвлэх, хувилах төхөөрөмж болон бусад хэрэгслүүд” гэж заасныг зөрчсөн байна.

3.1.2 Эрсдэл:

Дансны ангиллын дагуу хийгдэх бусад тооцоолол буруу илэрхийлэгдэх, санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал батламж мэдэгдэл хангагдахгүй байх

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан хөрөнгийн ангилалыг баримтлан үнэн зөв ангилж бүртгэж байх

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Алдааг засварлана. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй ажиллах талаар хариу ирүүлсэн.

3.2 Балансын данстай холбоотой асуудал

3.2.1 Илрүүлэлт:

Насжилт өндөртэй авлагын 13.6 сая төгрөгийн үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалтыг зөрчсөн байна.

3.2.2 Эрсдэл:

Найдваргүй авлага үүсэх, санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг батламж мэдэгдэл хангагдахгүй байх

3.2.3 Зөвлөмж:

Авлагын үлдэгдлийг харилцагчидтай тооцоо нийлж актаар баталгаажуулах, авлагыг барагдуулах, хуулийн заалтыг хэрэгжүүлэн ажиллах

3.2.4 Байгууллаас өгсөн хариу, тайлбар:

Зөрчлийн давтан гаргахгүй, хэрэгжүүлэн ажиллана

3.3 Балансын данстай холбоотой асуудал

3.3.1 Илрүүлэлт:

Бараа материалын тооллого үйлдсэн боловч тооцоо бодсон акт үйлдээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалтыг зөрчсөн байна.

3.3.2 Эрсдэл:

Бараа материал бусад хөрөнгийн илүүдэл болон дутагдал гарах, санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал батламж мэдэгдэл хангагдахгүй байх

3.3.3 Зөвлөмж:

Жилийн эцсийн хөрөнгийн тооллогын үр дүнг үндэслэн тооцоог бодож акт үйлдэх

3.3.4 Байгууллаас өгсөн хариу, тайлбар:

Зөрчлийн давтан гаргахгүй, хэрэгжүүлэн ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2019 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийсэн санхүүгийн тайлан**4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		2018 оны 12 дугаар сарын 31	2019 оны 12 дугаар сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	141,184,144.65	28,570,181.80
1.1.2	Дансны авлага	48,345,208.50	245,411,647.30
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	10,733,999.10	-
1.1.4	Бусад авлага	22,434,467.05	23,382,182.13
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө	-	-
1.1.6	Бараа материал	190,067,327.91	158,424,524.72
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	52,551,184.53	5,531,556.49
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө		
1.1.9	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)		
1.1.10			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	465,316,331.74	465,316,331.74
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	1,772,206,689.75	1,718,702,972.77
1.2.2	Биет бус хөрөнгө	1,054,544.87	-
1.2.3	Биологийн хөрөнгө		
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт		
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө		
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө		
1.2.7	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө		
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө		
1.2.9			
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,773,261,234.62	1,718,702,972.77
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	2,238,577,566.36	2,180,023,065.21
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	34,694,921.97	62,578,783.66
2.1.1.2	Цалингийн өглөг	-	601,511.98
2.1.1.3	Татварын өр	37,379,038.51	111,793,064.70
2.1.1.4	НДШ–ийн өглөг	-	6,642,089.40
2.1.1.5	Богино хугацаат зээл	50,508,345.74	50,508,345.74
2.1.1.6	Хүүний өглөг		
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг	-	59,621,307.54
2.1.1.8	Урьдчилж орсон орлого		
2.1.1.9	Нөөц /өр төлбөр/		
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	7,611,564.03	382,666.75
2.1.1.11	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)-нд хамаарах өр төлбөр		
2.1.1.12			
	Богино хугацаат өр төлбөрийн дүн	130,193,870.25	292,127,769.77
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл		
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/		

2.1.2.3	Хойшлогдсон татварын өр		
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр		
2.1.2.5			
	Урт хугацаат өр төлбөрийн дүн	-	-
2.2	Өр төлбөрийн нийт дүн	130,193,870.25	130,193,870.25
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч:-төрийн	663,670,844.58	663,670,844.58
2.3.2	- хувийн		
2.3.3	- хувьцаат		
2.3.4	Халаасны хувьцаа		
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал		
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	1,131,277,077.24	1,131,277,077.24
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц		
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	50,850,848.30	53,340,848.30
2.3.9	Хуримтлагдсан ашиг	262,584,925.99	39,606,525.32
2.3.10			
2.3.11	Эздийн өмчийн дүн	2,108,383,696.11	1,887,895,295.44
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	2,238,577,566.36	2,180,023,065.21

4.2 Аудит хийсэн Орлогын дэлгэрэнгүй тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2018 оны 12 дугаар сарын 31	2019 оны 12 дугаар сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	1,592,220,375.65	843,452,007.72
2	Борлуулалтын өртөг	137,065,609.22	49,154,416.98
3	Нийт ашиг(алдагдал)	1,455,154,766.43	794,297,590.74
4	Түрээсийн орлого	5,269,088.72	7,920,000.00
5	Хүүгийн орлого	4,199,705.26	933,276.29
6	Ногдол ашгийн орлого	-	-
7	Эрхийн шимтгэлийн орлого	-	-
8	Бусад орлого	7,700.00	-
9	Борлуулалт, маркетингийн зардал		
10	Ерөнхий ба удирдлагын зардал	883,440,958.10	900,173,295.07
11	Санхүүгийн зардал		
12	Бусад зардал		
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	3,263,990.14	100,668.47
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
17	Бусад ашиг (алдагдал)	(66,088,973.03)	(56,342,005.93)
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	518,365,319.42	(153,263,765.50)
19	Орлогын татварын зардал	54,223,269.18	93,327.63
20	Татварын дараах ашиг (алдагдал)	464,142,050.24	(153,357,093.13)
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	464,142,050.24	(153,357,093.13)

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	/төгрөгөөр/	
		2018 оны 12 дугаар сарын 31	2019 оны 12 дугаар сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	1,700,759,836.41	749,432,406.97
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	1,597,675,239.35	682,865,796.69
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	-	
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	7,072,448.00	4,995,714.00
1.1.4	Буцаан авсан албан татвар	-	61,570,896.28
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	-	749,432,406.97
1.1.6	Бусад мөнгөн орлого	96,012,149.06	682,865,796.69
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	1,274,667,807.23	851,981,614.04
1.2.1	Ажиллагчдад төлсөн	338,725,379.84	327,034,635.94
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	98,290,241.76	100,565,808.85
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	73,187,848.00	73,923,030.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	21,845,498.00	21,267,558.47
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	16,200,000.00	13,084,500.00
1.2.6	Хүүгийн төлбөрт төлсөн	-	
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	183,189,378.01	33,000,000.00
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	-	428,328.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	543,229,461.62	282,677,752.78
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	426,092,029.18	102,549,207.07
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	4,199,705.26	933,276.29
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсны орлого		
2.1.3	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого		
2.1.4	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого		
2.1.5	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт		
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	4,199,705.26	933,276.29
2.1.7	Хүлээн авсан ногдол ашиг		
2.1.8			
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	343,648,385.00	998,800.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	343,648,385.00	998,800.00
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		
2.2.4	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа		
2.2.6	Бусад		
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-339,448,679.74	65,523.71
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)		

3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
3.1.2	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
3.1.3	Төрөл бүрийн хандив		
3.1.4			
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	37,172,850.00	10,000,000.00
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
3.2.3	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн		
3.2.4	Төлсөн ногдол ашиг	37,172,850.00	10,000,000.00
3.2.5			
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-37,172,850.00	10,000,000.00
4	Валютын ханшийн зөрүү		
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	49,470,499.44	112,614,730.78
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	91,713,645.21	141,184,144.65
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	141,184,144.65	28,570,181.80

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эдийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2017 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл	663,670,844.58	178,847,922.38	53,340,848.3	-270,106,006.52	625,753,608.74
НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				68,548,882.27	68,548,882.27
Залруулсан үлдэгдэл	663,670,844.58	178,847,922.38	53,340,848.3	-201,557,124.25	694,302,491.01
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				461,460,418.42	461,460,418.42
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн		952,429,154.86			952,429,154.86
2018 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл	663,670,844.58	1,131,277,077.3	53,340,848.3	262,584,925.99	2,110,873,696.1
НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					
Залруулсан үлдэгдэл	663,670,844.58	1,131,277,077.24	53,340,848.3	262,584,925.99	2,041,252,388.6
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				-153,357,093.13	-153,357,093.13
Бусад дэлгэрэнгүй					
Өмчид гарсан					
Зарласан ногдол				-69,621,307.54	-69,621,307.54
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн					
2019 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл	663,670,844.58	1,131,277,077.24	53,340,848.3	39,606,525.32	1,887,895,295.4

4.5 2019 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшингийн гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт				
	а/ Гол нэр төрлөөр	0.0	0.0	-	0.0
	б/ Үнийн дүнгээр	997,000.0	851,372.0	(145,628.0)	85.4
2	Нийт орлого	997,000.0	851,372.0	(145,628.0)	85.4
	Үүнээс: цэвэр борлуулалт	989,804.0	843,452.0	(146,352.0)	85.2
	Түрээсийн орлого	7,196.0	7,920.0	724.0	110.1
3	Нийт зардал	993,454.0	1,005,669.7	12,215.7	101.2
	Үүнээс: Ерөнхий ба удирдлагын зардал	69,961.3	58,802.0	(11,159.3)	84.0
4	Татварын өмнөх ашиг	3,546.0	(153,263.8)	(156,809.8)	(4,322.2)
5	Цэвэр ашиг /алдагдал/	3,191.4	(153,263.8)	(156,455.2)	4,802.4)
6	Төрийн өмчийн ногдол ашиг	10,000.0	10,000.0	-	100.0
7	Борлуулалтын 1 төгрөгт ноогдох зардал	1	1.2	0.2	120.0
8	Хөрөнгө оруулалт	232,145.0	57390.1	(174,754.9)	24.7
9	Нийт авлага	74,980.0	268,793.8	193,813.8	358.5
	0-5 жилийн насжилттай	46,399.7	71,485.0	25,085.3	154.1
	5-10 жилийн насжилттай	28,580.3	197,308.8	168,728.5	690.4
10	Нийт өглөг	117,174.5	292,127.8	174,953.3	249.3
	Богино хугацаат өр төлбөр	117,174.5	292,127.8	174,953.3	249.3
	Урт хугацаат өр төлбөр	-	-	-	
11	Нийт ажиллагсдын тоо	39.0	39.0	-	100.0
12	Нийт цалингийн сан	381,118.7	380,162.0	(956.7)	99.7
13	Нэг ажиллагчийн дундаж цалин	1,058.7	1,056.0	(2.7)	99.7

5. Алдаа, зөрчлийн нэгтгэл

Огноо: 2020.02.14	Аудитын нэр: Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төвийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд	Аудитын код: САГ-2020-/30/-СТА- ТӨҮГ
Шалгагдсан байгууллагын нэр: Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв ТӨХК	Сая төгрөгөөр	

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Насжилт өндөртэй авлагагуудад тооцоо нийлсэн акт үйлдээгүй.	13.6	Зөвлөмж өгсөн	Захирал Ерөнхий нягтлан бодогч	Ц.Цэрэн Г.Эрдэнэжаргал
2	Бараа материалын тооллого үйлдсэн боловч тооцоо хийлсэн акт үйлдээгүй.		Зөвлөмж өгсөн	Захирал Ерөнхий нягтлан бодогч	Ц.Цэрэн Г.Эрдэнэжаргал
3	Хүлээн авалтын зардал болон хувийн хэрэглээний зардалд төлсөн НӨАТ-ыг төсөвт төлөх НӨАТ-аас хасч тоосон	1.4	Төлбөрийн акт тогтоох	Захирал Ерөнхий нягтлан бодогч	Ц.Цэрэн Г.Эрдэнэжаргал
4	Компьютер болон бусад дагалдах хэрэгслийг машин тоног төхөөрөмжийн ангилалд бүртгэсэн		Зөвлөмж өгсөн	Захирал Ерөнхий нягтлан бодогч	Ц.Цэрэн Г.Эрдэнэжаргал
	ДҮН	15.0			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР АКТ

2020 оны 03 дугаар сарын 20

№ 02/66

Улаанбаатар хот

СЭГ-2020/30/СТА-ТӨВ

Төсөвт төвлөрүүлэх тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2-т заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасан цаглабарт хугацааны дагуу Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв ТӨҮГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хүлээн авалтын болон хувийн хэрэглээний зардалд төлсөн Нэмэгдсэн өртгийн албан татвар 1,388,155.0 төгрөгийг төсөвт төлөх НӨАТ-аас хасч тооцсон байна.

Энэ нь Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.6-т “Дараах бараа ажил үйлчилгээг импортоор оруулах, худалдаж авахад төлсөн албан татварыг албан татвар суутган төлөгчийн төлөх уг албан татварын нийт дүнгээс хасахгүй: 14.6.2 хувийн болон ажиллагсдын хэрэгцээнд зориулан худалдаж авсан бараа ажил үйлчилгээ” гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, “Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 3.1-т заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Төсөвт төлөх Нэмэгдсэн өртгийн албан татвараас хасч тооцсон хүлээн авалтын болон хувийн хэрэглээний зардалд төлсөн Нэмэгдсэн өртгийн албан татвар 1,388,155.0 төгрөгийг Үндэсний аудитын газрын Төрийн сангийн 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх,
2. Актын биелэлтийг 2019 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төвийн захирал Ц.Цэрэн, Ерөнхий нягтлан бодогч Г.Эрдэнэжаргал нарт хариуцуулав.

АКТ

ТОГТООСОН:
 САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
 ЗАХИРАЛ БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
 Ц.НАРАНЧИМЭГ
 АУДИТОР Л.МӨНХЦАЦРАЛ

ГЭРЭЭГЭЭР ГҮЙЦЭТГЭГЧ:
 ЦЭГЦТӨВ БОГД АУДИТ ХХК-ИЙН
 ЗАХИРАЛ Н.ЦЭРЭНХАНД

ЗӨВШӨӨРСӨН:
 СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧНИЙ
 ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРАЛ
 Ц.ЦЭРЭН
 ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ
 Г.ЭРДЭНЭЖАРГАЛ

Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д “Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ” гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.

\\10.10.10.20\Richie_Kherep\Akt\2020\0316SAG5.Docx

001090143